



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/85

Хуурч

**Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Ойн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Шүрэнгийн адаг, Мойлт нуга, Баяннуга, Эрээн хайлааст, Дээд, доод хоолой, Бургасан ой зэрэг газруудад 2022 оны 06 дугаар сарын 17-ноос 06 дугаар сарын 30-ны хооронд 13 хоногийн хугацаанд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил гүйцэтгэх болсон тул хортон шавжтай тэмцэх тэмцлийн ажил хийгдэж байгаа дээрх газруудад аялал, зугаалга хийх, жимс, эмийн ургамал түүх, мал бэлчээхийг хориглосугай.

2.Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажилд хяналт тавьж ажлын явцыг цаг тухайд нь мэдээлж байхыг Байгаль орчны мэргэжилтэн (И.Наранбаатар), Байгаль хамгаалагч (Ц.Мөнхтөр) нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ууганбаяр)-д даалгасугай.



Ц.БАЯНБААТАР